



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 1156.

Мандалговь.

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн Газрын 133-р тогтоолоор батлагдсан "Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам"-ын 4.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгаас Дорноговь аймгийн Их-Хэт, Алтанширээ, Дэлгэрэх, Даланжаргалан, Айраг, Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь, Баянтал, Төв аймгийн Баян, Баянцагаан, Баянжаргалан, Хэнтий аймгийн Галшар, Дархан зэрэг отор нүүдлийн төвлөрөл ихтэй эдгээр 13 суманд өвөлжиж, хаваржиж буй малчдын зүй бусаар хорогдсон малын сэг зэм устгал, хүн малын эрүүл мэндийн үзлэг үйлчилгээ үзүүлэх болон бусад ажлыг зохион байгуулахад шаардлагатай санхүүжилтийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Сэг зэм устгах ажлын зардалд шаардагдах 13,000,000 (арван гурван сая) төгрөгийг хандив тусламжийн хөрөнгөнөөс гаргаж олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван)-д, тухайн ажлыг технологид хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, мэргэжил арга зүй удирдлагаар хангаж, биелэлтэд хяналт тавьж дээрх сумдын удирдлагуудтай хамтарч ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга (Ш.Мөнхдүүрэн), аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210437